Buddha's Wisdom Changes Your Life
SHAN ZAI
2011 10
Volume 73
Rissho Kosei-kai

## Цагаан Лянхуа Цэцгийн Судар Зөгнөлийн үг дамжуулсан нь, 6-р бүлэг

## The World of the Lotus Sutra

Шагжамуни бүх хүмүүст хандаж ийнхүү өгүүлэв:
“Махакашьяпа нь үүнээс хойш олон будда нарт өөрийгөө зориулж,олон ч хүнийг сургаалын зам уруу оруулж эцэст нь Будда болно.Буддагийн нэрийг Гэрэл Цацруулсан Будда гэж нэрлэж,түүний орныг Гэрэл Цацруулсан Буянт орон гэж нэрлэгдэж,түүний эрин үеийг Эрхэм Агуу Чимэглэлт гэж нэрлэх болно.Түүний оронд буддын сургаалыг эрхэмлэн дагах хүн олноор байх болно.Мөн уг сургаалыг хүсэн мөрөөдөх хүн ч ихээр байх болно.Буддын сургаалд саад болох зүйл үгүй бөгөөд чөтгөр адгуус байсан ч бүгд эсрэгээр уг сургаалыг хамгаалах болно.”

Махакашьяпагийн ирээдүйн зөгнөлтийг сонссон бүх бодисадва нар өөрийнхөө сэтгэлийг “Их Хааны идээ”гэсэн үлгэрлэлээр илэрхийлэв:
“Бид одоо хоол хүнсгүй оронгоос ирсэн өлөн хүмүүс мэт бөгөөд хааны гэнэтийн дайлалтанд очиж байгаа мэт санагдаж байна.Хэт их тансаг хоол хүнсээр дүүрсэн дайлалт учраас бид үнэхээр идэж болох эсэхээ мэдэхгүй эргэлзэн сандарч байна.Хэрэв хаан бид нарт идэж болно л гэвэл бид санаа амарч идэж чадна. Үүнтэй адил бид хэзээ нэгэн цагт Будда болж чадна гэж дуулаад өөртөө итгэж чадахгүй айж сандарч байна.Энэ бол хааны идээ нүдний өмнө байгаа боловч идэж болох эсэхийг мэдэхгүй байгаатай адил юм.хэрэв Шагжамуни бидэнд “Чи ч гэсэн Будда болж чадна”гэж хэлбэл бидний санаа амрах болно.Тиймээс бидэнд ч Будда болох зөгнөлийг хэлж өгнө үү.Тэгвэл бид хааны идээнээс айлтгүй идэж чадахтай адил хүмүүсийн төлөө бодисадвагийн үйл хийж ертөнцийн төлөө үйлчилж явах болно.”

Үүнийг сонссон Шагжамуни нь шавь нарынхаа бодол хүслийг сайвтар ойлгож,тэнд байсан бүх бодисадва,шавь нарт зөгнөлийнхөө үгээ дамжуулжээ.Тэгээд эцэст нь ингэж хэлэв:”Надад байсан агуу том дөрвөн шавь маань ийнхүү үүнээс хойш нэдэн таван зуун болж өслөө.Тэдгээр хүмүүст ч зөгнөлийнхөө үгээ дамжуулья.Бүгд аажим аажмаар даяан хийснээр Будда болох хүмүүс юм.Үүнд би ба та бүхэн,мөн өнгөрсөн амьдралын хооронд уялдаа холбоо байгаа юм.Одоо би та нарт үүний тухай ярьж өгье,сайвтар сонсоорой”.



# Хамтдаа сургаалын ертөнц үрүү

РКК-ийн Ерөнхийлөгч
**Нивано Ничико**

## Сэтгэлийн хөдөлгөөнөө дамжуулья



Шагжамүнигийн үгэнд ийм нэгэн үг байдаг:
"За,сургаалаа дамжуулах аянд гарцгаая.Олон хүний ашиг, аз жаргалын төлөө сургаалаа айлдая.Ертөнцийг нигүүлсэхүйн нүдээр харж,энэ дэлхийн амар амгалангийн төлөө Язгуурын Үнэний сургаалыг биелүүлэн гүйцэтгээе"
Энэ бол Шагжамүни нь анх ард түмний дэргэд сургаалаа айлдаж явна гэсэн амлалт байсан гэдэг.Энэ үгийг хэлж байх үед Шагжамүнигийн сэтгэл Язгуурын Үнэнийг гэгээрсэн баяр баясгалан,хүмүүст сургаалаа айлдах гэсэн сэтгэлийн хөдөлгөөнөөр дүүрэн байв.Одоогийн бид нарын амьдралын тулгуур болсон Шагжамүнигийн сургаал нь анх ингэж эхэлж байсан байна.

Мөн бид нар ч сургаалтай учирснаар олон баяр баясгалан,сэтгэлийн хөдөлгөөн амсан билээ.Тэрхүү баяр баясгалан,сэтгэлийн хөдөлгөөн нь бидний аврал ч болдог.Тэгвэл бид ч Шагжамүнитэй адил тэдгээр сэтгэлийн хөдөлгөөн,баяр баясгаланг сургаалыг дамжуулах энерги болгон хувиргаж,Буддын шашны ачаар аврагдаж чадсан баяр хөөрөө бусдад дамжуулж явах нь нэг ёсондоо бидний хувь заяа байж магадгүй юм.

## Хүн нигүүлсэхүй сэтгэлтэй болж чаддаг

Манай байгууллагын гишүүн элсэнгүүтээ шууд даяан хийж болдог.Гэвч буддын сургаал бол жаахан суралцаад л шууд ойлгодог тийм амар зүйл биш билээ.Тийм учраас би ч гэсэн урьд нь “энэ бол тийм ч амар зүйл биш”гэж боддог байлаа.Дараагаар яагаад тэгж болдогийг ойлгосон юм.Энэ нь хүн өөрөө аврагдсан бол тэрхүү үеийн сэтгэлийнхээ хөдөлгөөнөө бусдад дамжуулахад л тэр нь даяан болдог юм байна.

Талархалтай,баяртай гэсэн сэтгэлийг бол хүнд дамжуулахгүйн аргагүй зүйл юм.Ялангуяа шашны ертөнцөд бол үүнийг хүнд чин сэтгэлээсээ дамжуулах нь чухал бөгөөд энэ нь олон хүний сэтгэлийг хөдөлгөж,аврах түлхүүр болдог байна.Мөн сэтгэлийн аврал олж,баярлаж байгаа хүнийг хараад хэн ч гэсэн бас баярлана.Энэ бол хүний сэтгэлийн үндсэн мөн чанарыг хөдөлгөх чадвар бөгөөд хүнийг сургаалын ертөнц рүү дагуулан оруулах буянтай шалтаг болдог байна.

Ийнхүү хүнтэй учирч,сургаалаа дамжуулснаар нигүүлсэхүйн сэтгэл гүнзгийрч, хүний мөн чанараа улам дээшлүүлэн хөгжүүлж чадна.Энэ утгаараа сургаалын даяан бол бид бүхний сэтгэлийн хөгжил болдог байна.

Сургаалыг дамжуулснаар бусдыг нигүүлсэхүйн сэтгэлээр бодох сэтгэл төрдөг байна.Мөн тэр үед бусдаас хатуу үг сонссон ч сэтгэлээ барьж сурдаг хүн ч бий.Ийм дадал бол дараагийн учралын үр болж,сэтгэлийг хөгжүүлэх шим тэжээл болдог юм.

Хүнд сургаалыг дамжуулан заах үед тухайн хүнд таарсан арга барил чухал болдог байна.Цагаан Лянхуа Цэцгийн Судартэдгээр уран аргын тухай олноор тайлбарлан бичсэн байдаг.Гэвч хүнийг сурган хүмүүжүүлэх хамгийн агуу арга бол хүний үндсэн мөн чанарт байдаг байна.

Шагжамүнигийн нэгэн шавь болох Ангримара нь олон хүн алсан хүн байв.Түүний сэтгэлийн доторыг мэдэрч чадсан Шагжамүни нь түүнд сургаалаа айлдсан билээ. Шагжамүнигийн нинжин сэтгэлийг мэдэрсэн Ангримара нь засарч:”Ямагт айж явдаг байсан бол одоо би багш таны ач буянаар үнэхээр аз жаргалтай болж чадлаа”гэсэн гэдэг.

Ийнхүү Шагжамүнигийн сургаалын даяан нь анх нигүүлсэхүйн сэтгэлээс үүдэн эхэлсэн байна.Тиймээс ч хүнийг сургаалын замд оруулахад нинжин сэтгэл хэрэгтэй байдаг билээ.

Амьд буй бүх хүмүүс төрөлхийн бурханлаг мөн чанартай байдаг бол нигүүлсэхүйн сэтгэл ч хүний хамгийн үндсэн мөн чанар гэдэг юм.

“Косэй”2011 оны 10 сарын дугаараас
Translated by Kosei Publishing Company



# Инээмсэглэл бол тэнгэрийн цэцэг

РКК-ын дараах үеийн ерөнхийлөгч Нивано Коошо багш

## Мартсан зүйл

Том охин маань 5-р ангид байсан үеийн явдал юм.Ням гаригийн орой 7 цагийн үед охин маань гэнэт дэвтрээ барин гүйж ирээд "Яанаа,энэ даалгаврыг маргааш хүртэл хийх ёстой байсан юм" гэдэг байна.Тэр нь хөдөлмөрийн хичээлийн даалгавар байсан бөгөөд тэдэн номерийн өнгийн утас,ийм тийм дугаарын эсгий даавуу,зүүлтний цагираг худалдан авч бэлдэж хий гэж гэж бичээстэй байв.Миний оёдлын хайрцгийг хичнээн ухсан ч тэдгээр зүйл нь гарч ирсэнгүй.

"Эртхэн хэлэхэд яадаг юм" гэж зэмлэсэн ч одоо болсон хойно яах ч аргагүй байлаа.Том охиндоо хэр барагтаа анхаарал тавьж чаддаггүй тул энэ удаа туслах гэж хичээн "Дэлгүүр хаачихсан байж магадгүй ч юу ч гэсэн хоёюулаа яваад үзье"гээд охиноо дагуулан гарсан юм.

Аз болж дэлгүүр онгорхой байв.Хэрэгтэй байсан зүйлээ аваад харих замдаа "Үүнээс хойш эртхэн хэлж бэлдэж бай"гэж хэлэхэд охин маань санаа нь амарсан шинжтэй толгойгоо дохив.

Маргаашийн өглөө нь том охиноо дүүтэй нь хамт сургуульд нь хүргэж өгөөд гэртээ байтал утас дугарч,том охин маань ярьж байдаг байна:"Өчигдөр авсан нөгөө ууттай юмаа үүдэнд орхиод ирчихлээ,яанаа?Одоо би галт тэрэгний буудал дээр байна" Өдий хүртэл ганц ч удаа юмаа мартаж үзээгүй охин маань яах ч аргагүй байдалтай байв."За,хүлээж бай.Ээж нь одоо аваад очъе"гээд би тэр өглөө харин ямар азаар өөр ажилгүй байсан юм шууд машиндаа суугаад галт тэрэгний буудал уруу зүглэсэн билээ.Замдаа "Өчигдөрхөн арай чүү гэж юмаа амжиж авчихаад тэгээд мартаад явна гэсэн чинь юу гэсэн үг вэ?"гээд уур хүрэн загинах хүсэл маань буцалж байв.Гэтэл тэр үед толгойнд "мартая гэж

**Нивано Коошо**

Нивано Ничико ерөнхийлөгчийн том охин болж Токиод мэндэлсэн. Хуулч мэргэжлээр их сургуулиа дүүргэсний дараагаар РКК-ын удирдах албаны мэргэжилтэн бэлтгэх “Гакурин” сургуулийн үндсэн ангид элсэн суралцаж төгссөн.

Өдгөө Цагаан Лянхуа Сударыг судлангаа Косей Кайгийн гишүүд болон сүсэгтэн олонд ном айлдаж, гадна дотны шашинтнуудын хамтын ажиллагаан дээр анхааран ажиллаж байна. Түүнчлэн дараа үеийн ерөнхийлөгчөөр сонгогдох дияаны үйлээ үргэлжлүүлсээр байгаа. Мүнэхиротой гэрлэсэн бөгөөд нэг хүү, гурван охины ээж болсон.



мартаагүй.Мартахгүйн тулд зориуд үүдэнд тавьж орхиод гарах үедээ анзааралгүй орхиод явсан байх.Зориуд авсан юмаа мартаж орхиод хамгийн их зовж гутарч байгаа нь охин маань юм байна.Тэгвэл би түүнийг үүнээс илүү их буруутгаж шүүмжлээд байх шаардлагагүй юм байна”гэсэн бодол төрөв.

Галт тэрэгний буудал уруу ойртоход охин маань дүүтэйгээ хамт хүлээж байв.Машиныхаа цонхоор ууттай юмыг нь өгөөд:”Амжсан нь яамай даа.Зүгээр зүгээр,сургуульдаа амжина.Тайван явцгаа.Өнөөдөр ч хөгжилтэй сайхан байгаарай”гэж хэлэхэд охины минь царай нь гэгээрч “За,ээж ээ,баяртай”гээд хэлээд явав.

Охиныгоо араас нь хараад би маш их баяртай байв.”Явах үед нь эвгүй муухай үг хэлж,охиныхоо нэг өдрийг устгаагүй нь болж.Түүний баяртайн аргагүй царайг харсан нь болж”гэж бодсон юм.

Өчүүхэн зүйлийн дотор ч нандин эрдэнэ байдаг тул үүнийг олж авч чадсан үед бид аз жаргал амсдаг байна.Мэдээж хэрэг үргэлж бүрэн төгс байж чадахгүй билээ.Гэвч бид Үүсгэн Байгуулагчаас аз жаргалтай болох ухааныг заалгаж авсан тул өдөр бүр нэг ч гэсэн илүү их аз жаргал олж аван,түүнийгээ шимтлэн амсаж амьдрахсан гэж бодох юм.

“Якүшин” 2010 оны 8 сарын дугаараас Translated by Kosei Publishing Company

Үүсгэн байгуулагч Нивано Никкё-гийн сургаал

# Хайр бол шим тэжээл юм

Өвс ургамал,цэцэг модонд мэдлэг,сонирхолгүй хүнд “Өдөр цэцэг ургамлыг минь гадаа гаргаж наранд байлгаарай” гэж хэлж захисан ч тэр чигээрээ цэцэгнүүдээ гадаа мартаж орхих явдал элбэг байдаг.

Гэтэл үнэхээр цэцэг ургамалд хайртай хүн бол жаахан хүйтэн салхи үлээнгүүт л цэцгээ шууд далд хийж,нартай үед аль болох наранд сайн байлгах гэж цэцгээ тордож,хайрладаг байна.Өмнөх жишээний хүн ба уг жишээний хүний цэцэгнүүд хэрхэн яаж ургаж цэцэглэх нь ойлгомжтой биз ээ.

Нэг сэтгүүлд германы өнчин хүүхдүүдийн хоёр асрамжийн газрын тухай бичсэн байсан.Хоёр асрамжийн газар нь яг адилхан хоол хүнстэй байсан боловч нэгнийх нь хүүхдүүдийн өсөлт маш хурдан байсан гэнэ. Яагаад тийм ялгаатай байгаа бол гэж шим тэжээлийн судлаач шалтгааныг хайтал өсөлт сайтай асрамжийн газрын захирал багш нь хүүхдүүдийг өөрийн хүүхэд мэт хайрлаж,нус нь гармагц шууд арчиж өгөн,зав л гарвал хүүхдүүдийг өвөр дээрээ суулгаж хайрлан өсгөдөг байсан байна.

Энэ бол хүнийг өсгөхөд хамгийн чухал зүйл юу байдаг вэ гэдгийг сайн нотолж өгсөн жишээ болов уу.

Үүсгэн Байгуулагчийн Үг 5 (Kosei Publishing Co.), 146-147х

## Рисшо Косей Кайгийн тухай

Рисшо Косей кай нь 1938 онд Нивано Никкё болон Наганүма Мёко нарын санаачилгаар үүсэн байгуулагдсан юм. Манай байгууллага нь “Лянхуа цэцгийн гурван судар”-ыг номлолынхоо эх үүсвэр болгож, гэр бүлээрээ шүтэх шашины нэгэн шинэ хэлбэр бөгөөд сургаалийг амьдрал ахуй, нийгэмд хэрэгжүүлж аз жаргалтай амьдрал, гэгээтэй нийгэм, дэлхийн энх тайвныг зорьдог юм.





SHAN-ZAI Volume 73 (October 2011)

[Эрхлэн гаргагч] Рисшо Косей Кай Сургаал дэлгэрүүлэх олон улсын төв.
**Хаяг:** Fumonkan, 2-6-1 Wada Suginami-ku, Tokyo, 166-8537 Japan, **TEL:** 03-5341-1124 FAX: 03-5341-1224, **E-mail :** shanzai@kosei- kai.or.jp


※Энэхүү сэтгүүл нь Япон, Англи, Хятад, Солонгос хэл дээр тогтмол хэвлэгдэн гардаг бөгөөд зарим дугаар нь бусад орны хэл дээр ч хэвлэгдэн гардаг. ※Санал, сэтгэгдэл байвал бидэнтэй холбоо барина уу. ※ Хувийн зорилгоор ашиглах тохиолдолд Олон улсын салбартай холбоо барина уу.

# Rissho Kosei-kai Overseas Dharma Centers 2011

## Rissho Kosei-kai International
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

### Rissho Kosei-kai International of North America (RKINA)
4255 Campus Drive, University Center A-245 Irvine,
CA 92612, U.S.A.
*Tel:* 1-949-336-4430 *Fax:* 1-949-336-4432
*e-mail:* info@rkina.org http://www.buddhistcenter-rkina.org

### Branch under RKINA
**Rissho Kosei-kai of Tampa Bay**
2470 Nursery Rd.Clearwater, FL 33764, USA
*Tel*: (727) 560-2927
*e-mail*: rktampabay@yahoo.com
http://www.rkina.org/tampabay

### Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huankhwang
Bangkok 10310, Thailand
*Tel*: 66-2-716-8141 *Fax*: 66-2-716-8218
*e-mail*: thairissho@csloxinfo.com

### Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii
2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
*Tel:* 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
*e-mail:* info@rkhawaii.org http://www.rkhawaii.org

**Rissho Kosei-kai Maui Dharma Center**
1817 Nani Street, Wailuku, Maui, HI 96793, U.S.A.
*Tel:* 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4265

**Rissho Kosei-kai Kona Dharma Center**
73-4592 Mamalahoa Highway, Kailua, Kona, HI 96750, U.S.A.
*Tel:* 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

### Rissho Kosei-kai Buddhist Church of Los Angeles
2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
*Tel:* 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
*e-mail:* rk-la@sbcglobal.net http://www.rk-la.com

**Rissho Kosei-kai Dharma Center of San Antonio**
6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
*Tel:* 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
*e-mail:* dharmasanantonio@gmail.com

**Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado**

**Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas**

### Rissho Kosei-kai of San Francisco
1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
*Tel:* 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-5569
*e-mail:* rkksf@sbcglobal.net

**Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center**
28621 Pacific Highway South, Federal Way, WA 98003, U.S.A.
*Tel:* 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
*e-mail:* rkseattle@juno.com

**Rissho Kosei-kai of Sacramento**

**Rissho Kosei-kai of San Jose**

**Rissho Kosei-kai of Vancouver**

**Lotus Buddhist Circle**
851 N. San mateo Drive, San Mateo, CA 94401, U.S.A.

### Rissho Kosei-kai of New York
320 East 39th Street, New York, NY 10016, U.S.A.
*Tel:* 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
*e-mail:* koseiny@aol.com

**Rissho Kosei-kai of Chicago**
1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056, U.S.A.
*Tel & Fax:* 1-847-394-0809
*e-mail:* murakami4838@aol.com

### Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma
2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112, U.S.A.
*Tel & Fax:* 1-405-943-5030
*e-mail:* ok.risshokoseikai@gmail.com http://www.rkok-dharmacenter.org

**Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas**

**Rissho Kosei-kai Buddhist Center of Klamath Falls**
724 Main St., Suite 214, Klamath Falls, OR 97601, U.S.A.
*Tel:* 1-541-810-8127

**Rissho Kosei-kai, Dharma Center of Denver**
4340 E Kentucky Ave #345 Glendale, CO 80234, U.S.A.
*Tel:* 1-303-319-2765 *Fax:* 1-720-876-4534

**Rissho Kosei-kai Dharma Center of Dayton**
446 "B" Patterson Road, Dayton, OH 45419, U.S.A

### Risho Kossei-kai do Brasil
Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060, Brasil
*Tel:* 55-11-5549-4446 *Fax:* 55-11-5549-4304
*e-mail:* hiromi_mat@yahoo.com http://www.rkk.org.br

**Risho Kossei-kai de Mogi das Cruzes**
Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000, Brasil
*Tel:* 55-11-4724-8862

### Rissho Kosei-kai of Taipei
4F, No. 10 Hengyang Road, Jhongjheng District, Taipei City 100
*Tel:* 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433

**Rissho Kosei-kai of Taichung**
No. 19, Lane 260, Dongying 15th St., East Dist.,
Taichung City 401
*Tel:* 886-4-2215-4832/886-4-2215-4937 *Fax:* 886-4-2215-0647

**Rissho Kosei-kai of Jilung**

### Rissho Kosei-kai of Tainan
No. 45, Chongming 23rd Street, East District, Tainan City 701
*Tel:* 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

**Rissho Kosei-kai of Pingtung**
No. 4, Lane 60, Minquan Road, Pingtung City,
Pingtung County 900
*Tel:* 886-8-732-1241 *Fax:* 886-8-733-8037

### Korean Rissho Kosei-kai
423, Han-nam-dong, Young-San-ku, Seoul, Republic of Korea
*Tel:* 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
*e-mail:* krkk1125@hotmail.com

**Korean Rissho Kosei-kai of Pusan**
1258-13, Dae-Hyun-2-dong, Nam-ku, Kwang-yok-shi, Pusan,
Republic of Korea
*Tel:* 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

**Korean Rissho Kosei-kai of Masan**

### Branches under the Headquarters
**Rissho Kosei-kai of Hong Kong**
Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road, North Point,
Hong Kong, Special Administrative Region of the People's Republic of China
*Tel:* 852-2-369-1836 *Fax:* 852-2-368-3730

**Rissho Kosei-kai of Ulaanbaatar**
39A Apartment, room number 13, Olympic street, Khanuul district,
Ulaanbaatar, Mongolia
*Tel & Fax:* 976-11-318667
*e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

**Rissho Kosei-kai of Sukhbaatar**
18 Toot, 6 Orts, 7 Bair, 7 Khoroo, Sukhbaatar district, Ulaanbaatar, Mongolia

**Rissho Kosei-kai of Sakhalin**
1-72 Amyrskaya Street, Yuzhno-Sakhalinsk
693000, Russian Federation
*Tel & Fax:* 7-4242-43-78-56

**Rissho Kosei-kai (Geneva)**
1-5 route des Morillons P.O Box 2100 CH-1211 Geneva 2 Switzerland
*Tel:* 41-22-791-6261 *Fax:* 41-22-710-2053
*e-mail:* rkkgva@wcc-coe.org

**Rissho Kosei-kai of the UK**

**Rissho Kosei-kai of Venezia**
Castello-2229 30122-Venezia Ve Italy
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Paris**
86 AV Jean Jaures 93500 Tentin Paris, France
*Tel: Contact to Rissho Kosei-kai (Geneva)*

**Rissho Kosei-kai of Sydney**

## International Buddhist Congregation (IBC)
5F Fumon Hall, 2-6-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
*Tel:* 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
*e-mail:* ibcrk@kosei-kai.or.jp http://www.ibc-rk.org/

# Rissho Kosei-kai of South Asia Division
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218

## Thai Rissho Friendship Foundation
201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
*Tel:* 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
*e-mail:* thairissho@csloxinfo.com

## Rissho Kosei-kai of Bangladesh
85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
*Tel & Fax:* 880-31-2850238

**Rissho Kosei-kai of Dhaka**
House No.465, Road No-8, D.O.H.S Baridhera,
Dahka Cand.-1206, Bangladesh
*Tel:* 880-2-8316887

**Rissho Kosei-kai of Mayani**
Mayani Barua Paya, Mirsarai, Chittagong,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Patiya**
Patiya, Post office road, Patiya, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Domdama**
Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Cox's Bazar**
Phertali Barua Para, Cox's Bazar, Bangladesh

**Rissho Kosei-kai of Satbaria**
Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Laksham**
Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

**Rissho Kosei-kai of Raozan**
West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

**Rissho Kosei-kai of Chendirpuni**
Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

## Rissho Kosei-kai of Sri Lanka
382/17, N.A.S. Silva Mawatha, Pepiliyana, Boralesgamuwa, Sri Lanka
*Tel:* 94-11-2826367 *Fax:* 94-11-4205632

**Rissho Kosei-kai of Polonnaruwa**
No. 29 Menik Place, Kaduruwela, Polonnaruwa,
Sri Lanka

**Rissho Kosei-kai of Habarana**
151, Damulla Road, Habarana, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Galle**
No.43 Melban Park Akmeemana, Galle, Sri Lanka

**Rissho Kosei-kai of Kandy-wattegama**
12 Station Road, Kapugastota, Sri Lanka

## Branches under the South Asia Division

**Delhi Dharma Center**
B-117 (Basement Floors), Kalkaji,
New Delhi-110019, India
*Tel:* 91-11-2623-5060 *Fax:* 91-11-2685-5713
*e-mail:* sakusena@hotmail.com

**Rissho Kosei-kai of West Delhi**
A-139 Ganesh Nagar, Tilak Nagar
New Delhi-110018, India

**Rissho Kosei-kai of Kolkata**
E-243 B. P. Township, P. O. Panchasayar,
KOLKATA 700094, India

**Rissho Kosei-kai of Kathmandu**
Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal
*Tel:* 977-1-552-9464 *Fax:* 977-1-553-9832
*e-mail:* nrkk@wlink.com.np

**Rissho Kosei-kai of Lumbini**
Shantiban, Lumbini, Nepal

**Rissho Kosei-kai of Singapore**

## Other Groups

**Rissho Kosei-kai Friends in Shanghai**
1F, ZHUQIZHAN Art Museum, No. 580 OuYang Road,
Shanghai 200081 China